

САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮСЭЛТ ГАРГАСАН БАЙГУУЛЛАГА НЬ:

ХасЛизинг ХХК-тай хамтран бараа бүтээгдэхүүнээ борлуулахаар хүсэлт гаргаж байгаа байгууллага нь дараах шалгуурыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа;
- Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, тухайн аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан;
- Үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлдэг бизнесийн тодорхой байртай, эсхүл эд хөрөнгө борлуулах тогтмол сувагтай;
- Тухайн эд хөрөнгийг 6-аас доошгүй сарын хугацаанд худалдан борлуулсан туршлагатай;
- НӨАТ төлөгч байгууллага байх;
- Бараа бүтээгдэхүүндээ доод тал нь 6 сарын баталгаат засварын хугацаа өгдөг байх;
- Аль нэг байгууллагын албан ёсны борлуулагч эсхүл төлөөлөгч бол эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл, итгэмжлэл авсан байх;
- Шаардлагатай сэлбэг, эд ангийг нийлүүлэх буюу зуучлах боломжтой;
- Баталгааны хугацаанд өөрийн нөөц бололцоогоор засвар үйлчилгээ үзүүлэх боломжтой, эсхүл зуучлах боломжтой;

www.xacleasing.mn

САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АШИГЛАН ӨӨРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛАХ НЬ...



БОЛОМЖИТ БҮТЭЭГДЭХҮҮН:

- Газар тариалангийн техник;
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж;
- Эмчилгээ оношилгооны төхөөрөмж;
- Зам, барилгын техник хэрэгсэл;
- Уул уурхайн машин механизм;
- Шинэ суудлын автомашин;

ҮҮСЭХ ДАВУУ ТАЛМУД:

- Борлуулалтаа нэмэгдүүлэх;
- Худалдан авагчаа алдахгүй байх;
- Бэлэн мөнгөний урсгалаа сайжруулах;
- Бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулах;
- Санхүүгийн хүрэлцээ муу байгаа харилцагчиддаа бүтээгдэхүүнээ борлуулах;

Хэрэв Та дээрх шалгуурыг хангаж байгаа бол дараах бичиг баримтыг бүрдүүлж, албан ёсоор танилцуулна уу.

Энэхүү багц материал нь:

- Хамтран ажиллах тухай албан бичиг;
- Байгууллагын товч танилцуулга, бизнесийн түүх;
- Улсын бүртгэлийн гэрчилгээний болон НӨАТ-ийн гэрчилгээний хуулбар;
- Үйл ажиллагаанд нь тусгай зөвшөөрөл шаардагддаг бол лиценз, зөвшөөрлийн хуулбар;
- Албан ёсны борлуулагч эсхүл төлөөлөгч байгууллагуудтай хийсэн гэрээ хэлцэл, зөвшөөрөл, итгэмжлэлийн хуулбарууд;
- Сүүлийн улирлын Санхүүгийн тайлан, борлуулалтын тайлан;
- Санхүүгийн түрээсээр борлуулах барааны дэлгэрэнгүй танилцуулга болон үнийн санал, борлуулагч болон худалдааны төлөөлөгчдийн талаарх холбоо тогтоох мэдээлэл зэргээс бүрдэнэ.

Үүний дараа Компанийн зүгээс материалыг хүлээн аваад зохих шатны судалгааг хийж, хамтран ажиллах тухай шийдвэр гарсны дараагаар та бүхэнтэй холбогдон “Хамтран ажиллах тухай” гэрээ байгуулна.

Утас: 7011-2061, 7011-2067